



ТӨРИЙН ӨМЧИЙН ХОРООНЫ ДАРГА
Д.ЦОГТБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.05 № 1/04 УАГ-САГ/2014/28/СТАРТЦЗ

Зөрчлийг арилгах тухай

Төрийн өмчийн хорооны 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд хийсэн аудитын явцад дараах зөрчил илэрлээ.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас Чингэлтэй дүүргийн шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 101 тоот тогтоолын дагуу ТӨХ-ны 17000055548 тоот данс дахь өмч хувьчлалын орлого болох 3,000.000 /гурван сая/ ам. доллар буюу 3,540,150.000 төгрөгийг 2008 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр өөрийн Хадгаламж банк дахь 1700062781 тоот дансанд татан авсан талаар Сангийн яамтай авлага, өглөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ”, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4 дүгээр зүйлийн 4.11-д “авлагыг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусган санхүүгийн, тайланд тодруулга хийхдээ холбогдох УСНББОУС 1-ыг дагаж мөрдөнө” гэж заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулахын тулд акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн дээрх зөрчлийг арилгах албан шаардлагыг өгч байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан 3,540,150.000 төгрөгийг Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулан биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Д.Цогтбаатар, Ерөнхий нягтлан бодогч Ц.Болдбаатар нарт хариуцуулав.

АУДИТОР



Ш.ОТГОНБАЯР